

НИЙГМИЙН ШИНЭ БҮТЭЦ ТӨЛӨВШИН БУЙ ЯВЦ, ОНЦЛОГ

*Ц. Уртнасан
Философийн ухааны доктор (Ph.D)*

Манай орон дахь нийгмийн үзэгдэл, үйл явцын хурдан өөрчлөлт (тогтворгүй байдал), өмчийн олон хэлбэрийн төлөвшил, улс төрийн тогтолцоо ба засаглалын хэлбэрийн шинэчлэл, үйлдвэрлэлийн зохион байгуулалт, хэрэглээний хуваарилалт зэргийг тусгал, тэдгээрийн илрэл болсон нийгэм-ангийн тун өвөрмөц бүтэц төлөвших эхлэл тавигдаж байна.

Аливаа нийгмийн бүлэг, давхраа үүсэн төлөвших явц нь тодорхой нөхцөл байдал, цаг хугацааны үр дүн байдгийг эс тооцон элит бүлэг, дунд давхарга, үндэсний хөрөнгөтэн бий болчихсон мэтээр дүгнэвэл “монголд ажилчин анги нийгмийн манлайлагч хүч болсон” гэж үзэж байсантай яг адил хэрэг болно. Энэ зурвасхан хугацаанд илэрч буй хүн амын шинэ бүлэг, нийгмийн хэвтээ ба босоо чиглэлийн шилжилт буюу хөдөөнөөс хот руу, нэг анги бүлгээс нөгөөд шилжих (компаний захирал, дарга болон г.м) үйл явц нь эдийн засгийн өөрчлөлттэй холбоотой боловч голчлон улс төрийн уур амьсгалаас хамааралтай байгаа юм.

Өөрөөр хэлбэл нийгмийн бүтцийн шинэчлэл хангах объектив суурь бий болсон боловч тогтворжиж чадаагүй, субъектив хүчин зүйл (нийгмийн удирдлага, засгийн газрын бодлого үйл ажиллагаа)-аас ихээхэн шалтгаалж байна. Ийнхүү нийгмийн шинэ бүтэц төлөвшөөгүй, нийгмийн шилжилт дур зоргын шинжтэй байгаа болохоор тухайн асуудлын бодит байдлыг үнэн зөв тодорхойлоход бэрхшээлтэй.

Өрнөдийн социологичид шинэ анги үүсэх асуудлаар төрөл бүрийн үзэл бодол дэвшүүлсэн байх нь олонтаа. Тухайлбал, Унгарын социологич И.Селеньи шинэ анги үүсэхэд а/ Шинэ ангийн төрх байдлыг эзэмшихийг хүссэн, түүнийгээ эзэмших чадвар бүхий идэвхтэй хүчин. б/ Түүнийг хэрэгжүүлэх нийгэм-эдийн засгийн шинэ орчин в/ Энэхүү идэвхтэй хүчний ухамсар, үйл ажиллагааны шинэ хэлбэрийг тогтоох тухай бичсэн байдаг.

Манай орны шилжилтийн үе дэх нийгмийн шинэ бүлэг, давхрааны төлөвшлийн дээрх байдал өөрийн гэсэн онцлогтойгоор илэрч байгаа гэж үзэж болно. Хуучин нийгмийг өөрчилж шинэчлэлийг хүсч тэмүүлсэн улс төрийн хүчин төдийгүй нийгмийн бүлэг бүрэлдэж байхад түүнээс салж чадахгүй хүмүүс ч байсан хэвээр байна. Мөн нийгэм эдийн засгийн шинэ орчин, нөхцөл зохих хэмжээгээр төлөвшиж байгааг хэлэх хэрэгтэй.

Улс төрийн тогтолцооны эрс шинэтгэл; Өмчийн олон хэлбэрийн төлөвшил; эдийн засаг, үйлдвэрлэлийн цоо шинэ зохион байгуулалт хийгээд хуваарилалттай шууд холбоотойгоор хүн амын амьдралын түвшин огцом өөрчлөгдсөн юм. Чухам энэ байдал нь хувь хүнийг төрөл бүрийн нийгмийн бүлэгт хамааруулах (нэгтгэх) үндэс болж байна.

Дээр дурдсан улс төрийн тогтолцоо, өмчийн хэлбэр, үйлдвэрлэлийн зохион байгуулалт, хуваарилалт гэсэн язгуур өөрчлөлттэй холбогдох (дасах) нөхцөл байдал нийгмийн хуучин анги, бүлэг болон хувь хүмүүс болгонд харилцан адилгүй байлаа. Үүнийг үндсэнд нь дараах хоёр бүлэг хүчин зүйлст ангилж болмоор санагдана.

1. Хувь хүнээс үл хамаарах (заяагдмал) хүчин зүйл. Үүнд:

А. Юуны өмнө нийгмийн гарал байдал, өмч хөрөнгө уламжлан өмчлөх боломж, оршин суугаа нутаг орон хамрагдана. Эдгээр хүчин зүйл зах зээлийн харилцаанд анхнаасаа хэрхэн оролцож, нийгмийн ямар байр суурь эзлэхэд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн юм. Хөрөнгө мөнгөтэй, нийгэмд тодорхой байр суурь бүхий эрх мэдэлтэй хүмүүс тэдгээрийн хүүхдүүд зах зээлийн харилцааг эхлэхээс нь хувийн хэвшлийн аж ахуй байгуулж байхад олон түмэнд энэ тухай ойлголт тогтоо ч үгүй байсан билээ.

Б. Эрхэлж байсан ажил хөдөлмөрт холбогдох хүчин зүйлс. Зах зээлийн харилцаанд хөрвөх боломж, чадвараараа ажил мэргэжил бүхэн харилцан адилгүй байсан юм. Эдийн засагч, хуульч, гадаад хэлний мэргэжилтэй хүмүүст ийм боломж их байхад багш, хөдөө аж ахуйн мэргэжилтэн, эрдэм шинжилгээний ажилтан зэрэг хүмүүст энэ боломж хязгаарлагдмал байв. Үүнээс гадна аж ахуйн салбар, үйлдвэр, албан газрын онцлогоос хамааран зэх зээлд шилжих үеийн гарааны нөхцөл адилгүй байсан. Манай оронд үйлдвэрлэлийн хүрээнээс өмнө худалдаа арилжааны салбар зах зээлд эхлэн шилжсэн онцлогтой.

Ийнхүү хувь хүнээс шууд хамааралгүй нийгмийн зүгээс тулгасан гэж болох нөхцөл хүчин зүйлийн үйлчлэлээр хувь хүмүүс нийгмийн тодорхой бүлэгт хамаарагдсан гэж болно.

2. Хувь хүмүүсийн онцлогтой холбогдох хүчин зүйлс.

Зах зээлийн харилцаанд хэрхэн дасаж зохицох, амьдрал ахуйгаа яаж сайжруулах (доройтох), нийгэмд ямар байр суурь эзэлж, хэрхэн амьдрах буюу нийгмийн ямар бүлэгт орох нь тухайн хүний онцлогоос шууд хамааралтай. Хувь хүний эдгээр онцлогийг нарийвчлан үзвэл:

А. Хувь хүний тогтсон хандлага (баримжаалал) буюу бодгаль шинжээс зах зээлийн харилцаанд дасч зохицох, нийгэм дэх байр сууриа тогтоох, нийгмийн аль бүлэгт багтах нь ихээхэн хамааралтай байлаа. Өөрийнхөө боловсрол, мэдлэг, авьяас чадвараа дайчилж, хэвшсэн үзэл бодол, үнэт чанараа цаг үетэйгээ зохицуулан өөрчилж, нийгмийн шинэ орчин нөхцөлд таарч тохирсон үйл ажиллагаа явуулах мэдрэмж бүхий “идэвхтэй хүчин” нэгэнт бүрэлдсэн юм.

Гэтэл ийм боломж, чадвар өөрт нь бүрэн байгаа хэдий ч “социалист хүмүүжил”-дээ баригдан, бодгаль шинждээ хүлэгдэн, байдлыг харзнаж хүлээсэн, яах учраа олоогүй хүмүүс олон байсан юм. Байр суурь, нэр хүндээ ашиглан зээл авч хувийн өмчтэй болж, баян чинээлэг амьдрах эсвэл үзэл бодол, мэргэжлээ ашигтай байдал, албаар солих нь тэдний хувьд “ичгэвтэр” зүйл байв. Ийм байдал шилжилтийн эхэн үед түгээмэл байсан бөгөөд одоо өөрийн бодгаль шинжийг нийгмийн шинэ нөхцөл байдалтай зохицуулан өөрчлөх эрмэлзэл олон түмэнд эхлэн төлөвшиж байна. Энэ нь нийгмийн анги, бүлгийн ялгарал ихсэж хувь хүмүүс өөрийнхөө амьдрал, ахуйгаа хэрхэн яаж төвхнүүлэх ёстойг ойлгож эхэлсэнтэй холбоотой.

Б. Хүн ам зүйн онцлог. Энэ үзүүлэлтэд юуны өмнө хувь хүний нас, хүйс, гэр бүлийн байдал, хүүхдийн тоо хамаарагдахын зэрэгцээ эрүүл мэндийн байдал ч бас холбогдоно. Айл өрхийн амьжиргааны төвшин, өрхийн бүтэц, хүн ам зүйн онцлог нь зах зээлийн харилцаанд шилжихэд (дасах) хүчтэй нөлөөлсөн юм.

Манай орон зах зээлийн харилцаанд шилжих үед хувь хүнээс үл хамаарах ба хувь хүний онцлогтой холбоо бүхий энэ хоёр хүчин зүйл нь нийгмийн шинэ бүтэц тогтох, хувь хүний нийгмийн эрхт байдлыг (статус) тодорхойлох үндэс болсон юм. Нийгмийн шинэ бүлгийн шилжих хөдөлгөөн эрчимтэй явагдаж байгаа хэдий ч гарааны үеийн дээрх хүчин зүйл ул мөрөө үлдээсээр байгаа болно.

Харин хуучин нийгмийн бүтцийн задрал, нийгмийн шинэ бүлэг, давхраа үүсэх явц нийгэм-эдийн засгийн дараах орчинд хэрэгжиж байна. Үүнд:

Нэгдүгээрт, Хувийн өмчийн хэлбэр эдийн засагт голлох байр эзэлснээр нийгмийн шинэ бүлэг үүсч байна. Манай орны нийгмийн бүтцэд голлох байр суурь эзэлж байгаа малчид шилжилтийн үед нийгмийн төрх байдлаа өөрчилж хувийн аж ахуйтан болцгоосон юм. Үүнээс гадна хувиараа хөдөлмөр эрхлэгсэд, жижиг аж ахуйг хөтлөгсөд, пүүс компанийн эзэн, бизнесмен зэрэг ажил мэргэжлийн цоо шинэ бүлгүүд үүсч тэд улам бүр нийгмийн шинжийг илэрхийлэх болов.

Хоёрдугаарт, нийгмийн институтын бүтэц, зохион байгуулалтын эрс шинэчлэлтэй холбогдон нийгмийн шинэ бүлэг үүсч байна. Байнгын ажиллагаатай УИХ-ын гишүүд болон удирдлагын бүх шатанд ажиллагсад засаглал ба эдийн засгийн эрх, нөлөөллөөрөө урьдынхаасаа эрс ялгаатай болсон билээ. Мөн соёл, урлаг, боловсрол, шинжлэх ухааны байгууллагын ажилтан нараас чөлөөт уран бүтээлчид төрж, ажилчид хөлсний хөдөлмөр эрхлэгчид болж байгаа зэрэг нь дээрх хүчин зүйлтэй холбоотой.

Гуравдугаарт, Нийгмийн бүтцийг бүрдүүлэгч элемент бүрийн (анги, давхраа, нутаг дэвсгэрийн ба боловсрол мэргэжлийн бүтэц г.м) хуучин шалгуур, уламжлалт шинж чанар арилж иргэний нийгмийн үндсэн субъект болох хандлага бүрэлдэж эхэлжээ. Нийгмийн бүлэг болгон бодит шинж төрхийг олж байгаа юм. Энэ утгаараа манай оронд нийгмийн хуучин анги, бүлэг уламжлалт шинжээрээ нэгэнт оршин тогтнохоо больсон гэж болно.

Дөрөвдүгээрт, Аливаа хуучин тогтолцоог шинээр солиход сөрөг үр дагавар зайлшгүй дагалддаг. Тэгшитгэн хуваарилах зарчим, боловсрол, эрүүл мэндийн үнэ төлбөргүй үйлчилгээ, нийгмийн халамжинд дасч идээшсэн болохоор нийгмийн хуучин байр сууриа алдаж нийгмийн сөрөг үйлдэл, үйл ажиллагаатай холбоо бүхий ажил мэргэжил эрхлэх явдал ч дэлгэрч байна. Манай оронд гарч буй ийм төрлийн ажил-мэргэжлийн (шагчин, биеэ үнэлэгч, хог түүгчид, гэмт хэрэгтний г.м) янз бүрийн бүлэглэл нь түр зуурын үзэгдэл биш бөгөөд зах зээлийн нийгмийг байнга дагалдан явдаг жамтай. Ийнхүү ашиг сонирхол, хэрэгцээгээ танин мэдсэн бүлэг хүмүүс, тэрхүү хэрэгцээ сонирхлыг бүрдүүлэгч нийгмийн зохих орчин нэгэнт төлөвшиж байгаа нь нийгмийн анги бүлгийн задрал, шинэчлэлийг нөхцөлдүүлж байна.

Харин энэ хоёр хүчний ухамсар, идэвхтэй үйл ажиллагаа баттай тогтох явц нэлээн бэрхшээлийг туулах бөгөөд нийгмийн шилжилтийн хэд хэдэн үеийг туулж байж иргэний нийгэмд байдаг сонгодог бүтэцтэй болох байх. Нийгмийн босоо чиглэлийн хөдөлгөөнийг зохицуулж байдаг улс төрийн тогтолцооны арга, хэлбэр боловсронгуй болж, хэвтээ чиглэлийг зохицуулж байдаг эдийн засаг тогтворжиж, бие дааж чадсан цагт нийгмийн бүтцийн маргиналь шинж багасна.